



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/358

Алтай хот


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Цахим хөгжил, харилцаа холбооны яам, E-Академийн хамтарсан ажлын хэсэг тус аймагт Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ([www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn))-ийг хөгжүүлж, орон нутгийн нэг болон олон шатлалт үйлчилгээг системд нэвтрүүлэх, олон нийт иргэдэд сурталчилан таниулах зорилгоор ажилласантай холбогдуулан шаардагдах 781,500 (долоон зуун наян нэгэн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР